*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# ДОРНОД АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ Б. ЭНХТУУЛЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **ЗОРИЛТ 1. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ** | | | | | | | |
| 1.1 | Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага болон дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах. | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийн 100.0 аас доошгүй хувийг барагдуулж ажиллана | | 100 хувь | Нийгмийн даатгалын дотоодын хяналтыг сайжруулах, нийгмийн даатгалын сангийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх Нийгмийн даатгалын Ерөнхий газрын 08/2075 батлагдсан удирдамжын хүрээнд SICOS программын тэтгэвэр тэтгэмжийн олголтыг хянах ажлыг зохион байгуулан 2024 оны 6-10 сарын тэтгэврийн олголтыг хянаж гүйцэтгэлээ. Шалгалтаар өндөр насны тэтгэвэр илүү олгосон 14 иргэний 4,7 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний илүү дутуу олгосон 12 иргэний 6,3 сая төгрөг, тэжээгчээ алдсаны тэтгэвэр илүү олгосон 7 иргэний 2,9 сая төгрөгийн тэтгэврийг, жирэмсний | 2024.09.01 2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | болон амаржсаны тэтгэмжийн олголтыг 1 иргэнд 1,3 сая төгрөг давхардуулан олгосон, оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй иргэнд 2,0 сая төгрөг, хөдөлмөрийн чадвараа алдсаны тэтгэмжийг 1 иргэнд давхардуулан олгосон 2,2 мянган төгрөгийн зөрчил үүссэн байна. | | |
| 1.2 | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Зөрчлийн тухай хууль,Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж,үр дүнг тооцож ажиллана. | | 100 хувь | Зөрчлийн тухай хууль, зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зөрчлийн талаарх, гомдол, мэдээллийг хялбаршуулсан 4 байгууллагын материал хүлээн авсанаас 2 байгууллагын материалыг шийдвэрлэн хариуцсан прокурорт хянуулан 2 байгууллагын 1 иргэний материал дутуу буцааж 1 байгууллагын албан тоотод зөвлөгөө мэдээлэл өгч ажилллалаа.<br>Эрх бүхий албан тушаалтны оногдуулсан торгох шийтгэлийн биелэлтийн судалгааг сар болгон өссөн дүнгээр гаргаж прокурорын байгууллагад хүргүүлэн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явууласан 10 хэргийн биелэлтийг 100 хувь барагдуулан ажиллаж байна. | 2024.09.01<br>2024.12.31 | 100 |
| 1.3 | Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг | Шалгалтын үр дүнг хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас | | 100 | НДЕГ-ын 2024 оны 11 дүгээр сарын төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжын дагуу Ерөнхий газрын байцаагч нартай 2019-2023 оны тэтгэвэр тэтгэмжийн тогтоолт олголтыг үндэслэлийг шалгах анхан шатны баримт мэдээлэл болон сангийн өгөгдэлтэй мөн Малчнаар тэтгэвэр | 2024.09.01<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд хүргүүлэх | доошгүй хувийг барагдуулсан байна. | | | тогтоолгосон иргэдийн А данс болох үндсэн баримтыг Аймгийн архив болон сумын А дансны үндсэн баримттай тулган шалгах, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5.1.3-т заасны дагуу тэтгэвэр тогтоолгосон болон хүүхдийн тоогоор ажилласан жилээ 2020 онд нэмэгдүүлэн тооцуулсан эхчүүдийн хүүхдийн төрсний гэрчилгээг хянан шалгаж 42 тэтгэврийн хувийн хэрэгт УБЕГазраас хүүхдийн төрсний гэрчилгээний лавлагааг дахин авч ажиллаа. | | |
| **ЗОРИЛТ 2 : "ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 2.1 | Гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, бусад мэдээг тухай бүр гаргаж удирдлагад танилцуулж байх<br>- Сарын мэдээ,<br>- Улирлын тайлан,<br>Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | Тайлан мэдээг хугацаанд нь хийж гүйцэтгэх | | | Тайлант хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, бусад мэдээг тухай бүр хэлтсийн даргадаа танилцуулж ажиллалаа. Үүнд:<br>- Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 1 удаа<br>- Шийтгэлтийн хуудасны тайлан-2 | 2024.09.01<br>2024.12.31 | 100 |
| 2.2 | Иргэд даатгуулагчдаас ирүүлсэн өргөдөл хүсэлтийг хуулийн дагуу хугацаанд нь шийдвэрлэх | Хуулийн хугацаанд шийдвэрлэнэ | Хүсэлт гаргасан иргэдийн тоогоор | Хүсэлт гаргасан иргэдийн тоогоор | Иргэд даатгуулагч, аж ахуйн нэгж байгууллагуудаас биеэр болон утсаар, цахимаар ирүүлсэн хүсэлтүүдийг тухай бүрд нь шуурхай тодруулан шийдвэрлэж ажилласан. Иргэний гомдол ирснийг тухай бүрд нь шуурхай шийдвэрлэж гомдол гаргасан иргэнд болон холбогдох албан тушаалтанд хариу мэдэгдэн ажиллалаа. | 2024.09.01<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3 | Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг мөрдөж ажиллах | Стандартад нийцсэн байна | | | Хэлтсийн даргын тушаалаар томилогдсон "Баримт бичиг нягтлан шалгах комисс" /ББНШК/-ын хурлаар батлагдсан "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт"-ын дагуу<br><br>архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, баримт бичгийн стандартыг өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон ажилладаг | 2024.09.01<br>2024.12.31 | 100 |
| 2.4 | Ажил олгогч, даатгуулагчдын мэдээллийн нууцыг бусдад задруулахгүй ажиллах үүрэг хүлээх | Хуульд заасан мэдээллийг бусдад задруулахгүй ажиллана | | | Ажил олгогч, даатгуулагчдын мэдээллийн нууцыг бусдад задруулахгүй ажиллах үүргийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллав. | 2024.09.01<br>2024.12.31 | |
| 2.5 | "Нийгмийн даатгалын байцаагч /ажилтан/-ны үйлчлүүлэгчтэй харилцах журам"-ыг мөрдлөг болгон ажиллах | Өдөр тутмын ажилдаа мөрдөж ажиллана | | | "Нийгмийн даатгалын байцаагч /ажилтан/-ны үйлчлүүлэгчтэй харилцах журам"-ыг тогтмол мөрдлөг болгон ажиллаж даатгуулагч иргэд, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан нэг бүртэй эелдэг, найрсаг харилцахыг эрхэмлэн ажиллалаа. | 2024.09.01<br>2024.12.31 | |
| 2.6 | Үйлчлүүлэгчидтэй харилцах нээлттэй утас 70583046 үйлчилгээ | Өдөр тутмын ажилдаа мөрдөж ажиллана | | | Нийгмийн даатгалын ерөнхий газраас иргэд даатгуулагчидтай харилцах өрөөний утас 70583046 утсанд нийгмийн даатгалын үйлчилгээний талаар мэдээлэл авахаар тус утсанд холбогдсон иргэд даатгуулагчдын дуудлага бүрийг хариуцлагатай авч хүссэн мэдээллийг өгч ажилласан ба алдсан дуудлагыг эргэж залгаж тодруулан мэдээллийг түргэн шуурхай өгч шийдвэрлэж ажиллалаа. | 2024.09.01<br>2024.12.31 | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага барагдуулах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил | Авлага бууруулсан байх | | 80 хувь | Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр баталсан “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж авлага барагдуулах аян”-ы удирдамжийн дагуу 6-р багт хуваарилагдан Мэдээллийн технологи,сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Г.Наранбаяр, Тэтгэврийн байцаагч С.Болормаа Нийгмийн хамгааллын байцаагч Г. Цэрэнжаргал нартай хамтран 52-н ААН-ийн 262,250,942.18 төгрөгийн шимтгэлийн авлагыг барагдуулахаар ажиллалаа. 4 ААН-ийн арилжааны банкан дахь дансыг хаасан. 19 Аж ахуй нэгжийн 40,805,905 төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг барагдуулан ажиллалаа. | 2024.09.01<br>2024.12.31 | |
| 2. | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан байна. | 100 хувь | 100 хувь | Төрөөс нийгмийн даатгалын талаар баримтлаж буй бодлого, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд чанартай, хүртээмжтэй хүргэх, хууль сурталчилах, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэн ажиллаж байна<br><br>Иргэд, даатгуулагчаас нийт өргөдөл, гомдол, хүсэлт хүлээн авч шийдвэрлэсний амаар 25, бичгээр ирсэн 6 өргөдөл, хүсэлт ирсэн байна. | 2024.09.01<br>2024.12.31 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Бичгээр ирүүлсэн өргөдлийг төрлөөр нь ангилбал:<br>➢ Хүүхдээ асарч буй эхийн нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй: 3<br>➢<br>➢ Нийгмийн даатгалын шимтгэл дутуу төлсөн буруу орхигдуулсан: 2<br>➢ Тэтгэвэр тэтгэмж болон нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар зөвлөгөө мэдээлэл авсан:25<br>Дээрхи өргөдөл, гомдлыг хүлээн авч холбогдох хууль, тогтоомжийн дагуу хуулийн хугацаанд 100 хувь шийдвэрлэж ажиллалаа. | | |
| 3. | Ажил олгогч, иргэд, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчид, оюутан сурагчдад нийгмийн даатгалын ач холбогдол, нийгмийн даатгалын тухай хуулиудад орсон өөрчлөлт, сайн дурын даатгалын чиглэлээр сургалт зохион байгуулах | Сургалт зохион байгуулж, иргэд, даатгуулагчдын нийгмийн даатгалын талаарх мэдлэг, мэдээлэл дээшилж, хамралт нэмэгдсэн байна. | | 100 хувь | “Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил”-ийн хүрээнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийн ач холбогдолыг ажил олгогч, даатгуулагч, иргэдэд сурталчилах, мэдээлэл өгөх, зөвлөн туслах үйлчилгээг идэвхжүүлэх зорилгоор энэ 9 дүгээр сарыг “Нээлттэй мэдээллийн сар” болгон зарласаны дагуу 9 сарын 20-21 өдөр Шүр зах болон Хэрлэн Номин бизнесийн төвд ойрхон байрлах аж ахуй нэгжүүдэд Орлого шимтгэлийн байцаагч Түвшинбаатарын хамт зөвлөгөө мэдээлэл өгөн ажиллаа. | 2024.09.01<br>2024.12.31 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нийт 14 аж ахуй нэгж, 15 иргэнд нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах, нийгмийн даатгалын үйлчилгээ, шимтгэл төлөлтэй холбоотой асуудлаар заавар зөвлөгөө өгч 1 аж ахуй нэгж шинээр хамрагдахаар,1 аж ахуй нэгж шилжиж ирэхээр хүсэлтээ өгсөн. Өдөрлөгийн үеэр 5 иргэнийг шинээр сайн дурын даатгалд хамруулан ажилласан. | | |
| 4. | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр өргөнөөр сурталчлах; | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээ болон бусад хэлбэрээр олон нийтэд ойлгомжтой, шуурхай хүргэсэн байна. | | | Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, ач холбогдол, нийгмийн даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа, цаг үеийн мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн “Дорнод аймгийн нэгдсэн групп зар, Дорнодын ээжүүд, Дорнодын ажил хэрэгч бүсгүйчүүд” гэх мэт томоохон сүлжээгээр дамжуулан ХНХЯ болон НДЕГ-аас бэлтгэсэн мэдээллийг шэйрлэн түгээн ажилласан. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дуссан хугацаа | Биелэлт ийн хувь |

13

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **“ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ, САЛБАРЫН ХУУЛЬ, ДАГАЛДАН ГАРСАН ХУУЛЬ ТОГТООМЖИД ЗААСАН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ ЭЗЭМШИХ, ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД** | | | | | | | |
| 1. | Салбарын хэмжээнд болон аймаг, орон нутгаас, хэлтсээс зохион байгуулагдсан сургалтуудад хамрагдах | Хууль эрх зүй, цаг үеийн холбогдолтой мэдлэг, мэдээлэлтэй болсон байна | 100 | | - Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр шинэчлэн батлагдсан “Нийгмийн даатгалын багц хууль”-ийн сургалтуудад НДЕГ-аас цахимаар зохион байгуулахад оролцсон.<br>- *Sicos.ndaatgal.mn* шинэ системын ашиглалттай холбоотой 3 удаагийн Zoom сургалтанд холбогдох байцаагч, ажилтнуудтай хамтран оролцсон.<br>- НДЕГ-аас албан ёсоор зохион байгуулж буй “Монгол бичиг”-ийн 1 удаагийн сургалтад хамрагдаад байна. | | |
| 2. | Системын хэмжээнд шинээр нэвтэрсэн программ хангамж, хууль, журам, дүрмийг судлах | Хууль эрх зүй, цаг үеийн холбогдолтой мэдлэг, мэдээлэлтэй болсон байна | 100 | | Шинэ системтэй холбоотой албан ёсны сургалт, цахим уулзалтуудад оролцохоос гадна системын ажиллагаанд гарч байгаа гацалт, түүнээс үүдэлтэй алдааг залруулах зэрэг хүндрэлтэй асуудлуудыг цаг тухай бүрд нь судлан холбогдох мэргэжилтэн, албан хаагчидтай хамтран ажиллаж иргэд даатгуулагчдад чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч ажиллалаа.<br>Мөн шинээр мөрдөгдөж буй “Нийгмийн даатгалын багц хууль”, түүнийг дагалдан гарсан журам, дүрмийг судлан хэрэгжүүлэх ажлыг тасралтгүй хийж гүйцэтгэн ажиллалаа. | | |
| 3. | НДЕГ, НДГазар, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан сургалтад хамрагда | Сургалтад хамрагдсан байх | 100 | | -Төрийн албаны зөвлөлөөс 7 хоног бүр зохион байгуулдаг 7:4:10 Гэр бүл, хөдөлмөр,нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөрийн бодлогын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шинжээч О. Мягмарсүрэнгийн явуулсан "Төрийн албан хаагчийн цалин хөлс нийгмийн баталгааг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилт" сэдэвт сургалт, Үндэсний статистикийн хорооны дарга Б.Батдаваа нарын "Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа-II"-г зохион байгуулахтай холбоотой асуудлаар хийсэн сургалт мэдээлэл, "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр" Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан сургалтуудад тогтмол идэвхтэй хамрагдан сургалтаас олж авсан мэдлэгээ өдөр тутмын ажилдаа мөрдлөг болгон ажиллаж ирлээ. | | |
| 4 | Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг хөгжүүлэх зорилтын хүрээнд ашиглагдах программ хангамж, тоног төхөөрөмж дээр ажиллах чадварыг эзэмших | Ашиглагдаж буй программыг бүрэн ашиглаж чаддаг болсон байна | 100 | | Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг хөгжүүлэх зорилтын хүрээнд ашиглагдах программ хангамж, тоног төхөөрөмж дээр ажиллах чадварыг эзэмшихээс гадна шаардлагатай мэдээллүүдийг бүртгэх явцад хүндрэлтэй байгаа болон ажлын явцад илэрч байгаа зарим алдааг бүртгэн холбогдох мэргэжилтнүүдэд мэдээлж, засаж залруулах гэх мэт ажлуудыг хийж ажиллалаа. | | |

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХЯНАЛТЫН БАЙЦААГЧ Б.Энхтуул Б.ЭНХТУУЛ

2024.12.06.